

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Газар зүйн мэдээлэл.
Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт**

MNS 6925-3 : 2021

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН**

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Энэхүү стандартад Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт болон Олон улсын стандартын байгууллага (ISO)-ын 211-р стандартчиллын техникийн хороо (TC211-Geographic information/Geomatics)-ноос гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлага, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон хэсэгчлэн ашигласан.

Монгол Улсын Засгийн газраас үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Сайнбуян, доктор Б.Баяртунгалаг, А.Түрүүтүвшин, Д.Сайнбаяр, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, З.Нямбаяр, доктор, профессор П.Мягмарцэрэн, Д.Мөнхцэцэг, Д.Ундармаа, Э.Баярмаа, П.Нямдаваа, М.Мягмаржаргал нар хамтран гүйцэтгэсэн.

Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн ГМТ эрхлэгч доктор, дэд профессор Монгол улсын зөвлөх инженер Д.Түвшинбаяр редакц хийж, Монгол улсын зөвлөх инженер Я.Сандагдорж шүүмжийг хийсэн.

Стандартын төсөлд холбогдох байгууллагуудаас санал, шүүмжийг авч тусгасан.

СХЗГ-ын ахлах мэргэжилтэн Н.Батжаргал “Монгол улсын стандартчиллын тогтолцооны 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандарттай нийцүүлэн хянасан.

Стандартын төслийг “Газрын салбарын стандартчиллын техникийн хороо” /ТХ-36/- ны 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.estandart.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© **СХЗГ, 2021**

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

Агуулга

1 Хамрах хүрээ.....	1
2 Норматив эшлэл	1
3 Нэр томьёо, тодорхойлолт	2
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	2
3.2 Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт	3
4 Техникийн шаардлага.....	4
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих шаардлага	4
4.2 Атрибутад тавих шаардлага	6
4.3 Кодын жагсаалтад тавих шаардлага	6
4.4 UML диаграммд тавих шаардлага	7
4.5 Өгөгдлийн чанарт тавих шаардлага.....	7
А хавсралт (норматив) - Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга.....	9
В хавсралт (норматив) – Кодын жагсаалт.....	15
С хавсралт (норматив) – UML диаграмм	30
Д хавсралт (норматив) – Өгөгдлийн чанар	34
Ном зүй.....	37

Оршил

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандарт боловсруулах санаачилгыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачилсан бөгөөд энэхүү асуудлын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамтын оролцоотой бүтсэн баримт бичиг болно.

Стандартын төслийг нь холбогдох байгууллагууд буюу сонирхогч талуудаас өгсөн саналыг авч тусгасан бөгөөд хэрэглэх явцад гарсан дэвшилттэй болон дутагдалтай асуудлын хүрээнд стандартын үзлэгийг цаашид хийгдэх юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгох юм.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлсэн.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлсэн.

Энэхүү стандарт нь газар зүйн нэрийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Газарзүйн нэр олгосон буюу оноосон нэр бүхий газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудын нэрийн утга болон нэрийн мэдээллийн батлагдсан байдал, нэрийн ангилал зэрэг шинж чанарын мэдээллийг агуулахад оршино.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-3 : 2021
Geographic information. Data specification on Geographical name	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн С/36 дугаар тушаалаар батлав

Энэхүү стандартыг Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Газар зүйн нэрийн өгөгдлийн сан нь эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект, хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудуу, улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн доторх хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объектын нэрс түүний дагалдах бүх элементүүд, тэдгээрийн мэдээллийг агуулна.

Энэхүү стандарт нь газар зүйн нэрийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд газар зүйн нэрийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Огноо заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Огноо заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO/TS 19103:2005, Газар зүйн мэдээлэл – Ойлголтын схемийн хэл;

ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19109:2005, Газар зүйн мэдээлэл – Хэрэглээний схемийн дүрмүүд;

ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн суурь солбицол;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;

ISO/TS 19127:2005, Газар зүйн мэдээлэл – Геодезийн код ба параметрууд;

ISO 19131:2007, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт;

ISO 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;

ISO/DIS 19156, Газар зүйн мэдээлэл – Ажиглалт ба хэмжилт;

ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;

MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, хөрс, агаар, сансрын, газрын хэвлийн орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

дэлхийн гадаргаас шууд хэмжигдэх буюу хүний нүдэнд харагдах харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх орон зайн өгөгдөл

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрөл.

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрөл.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрсэлсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7**мета өгөгдөл**

орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогц (өгөгдлийн тухай өгөгдөл).

3.1.8**кодын жагсаалт**

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадаа ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.9**домэйн**

тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” байх ёстой гэсэн шалгуур домэйн болно.

3.1.10**газар зүйн нэр**

газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор оноосон нэрийг хэлнэ.

3.1.11**дэвсгэр нэр**

хүний нүдэнд тусах байгаль, газар зүйн тогтолцооны хэлбэр дүрс, шинж чанарыг тусган аливаа оноосон нэрийн суурь ухагдахуун болж газар усны нэрийн гарал ялгааг гаргаж өгдөг.

3.2 Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт**3.2.1****Character string**

тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005)

3.2.2**Date**

хугацааг заасан утгын төрөл. Огноо дангаараа болон огноо, цагийн хослол хэлбэрээр байж болно.

3.2.3**Date time**

цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005)

3.2.4**GM_Object**

геометрийн объектын ангилал зүйн язгуур анги бөгөөд Газар зүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг.

3.2.5

Identifier

өгөгдөл мэдээллийг хариуцагч эрх бүхий байгууллагаас олгосон орон зайн объектын танигч буюу тодорхойлогч. Энэ нь тухайн өгөгдлийг бусад программ, системүүд лавлах, холбох үед ашиглана. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005)

3.2.6

Number

тоолсон хэмжсэн үр дүнг илэрхийлдэг тоон төрлийн утга. Энэ нь ерөнхий төрөл бөгөөд тодорхой (exact), болон ойролцоо (approximate) гэж ангилагдана. (Эх сурвалж: ISO/TS 19103:2005)

3.2.7


URL

тухайн биетийн бичвэрийн тэмдэгтээр илэрхийлсэн холбоосны утга. (Эх сурвалж: ISO19136:2007)

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох **“өгөгдлийн багц”**, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй **“атрибут”**, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан **“кодын жагсаалт”** гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй байна. (1-р зургийг үзнэ үү)



1-р зураг – Газар зүйн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 Орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн А хавсралт норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр тус тусад нь нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Газар зүйн нэрийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хавсралтын хүснэгтийн дагуу **Газар зүйн нэр** гэсэн 1 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн санд 1 биет төрөл, 1 өгөгдөл төрөл агуулна.

4.2 Атрибурад тавих шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч **/External ID/** нь орон зайн объектын өгөгдлийн сангийн гадаад тодорхойлогч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” **/Local ID/**, “нэрийн талбар” **/Name space/**, “танигчийн хувилбар” **/Version ID/** гэсэн 3 атрибутаас бүрдэнэ.

4.2.3.1 “Дотоод танигч **/Local ID/**” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

4.2.3.2 “Нэрийн талбар **/Name space/**” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар **/Version ID/**” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

4.3 Кодын жагсаалтад тавих шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн санд 7 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу В хавсралтаас ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграммд тавих шаардлага

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг C хавсралтад үзүүлсэн UML (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language) диаграммын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад C хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 C хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна Газар зүйн нэрийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь газар зүйн нэрийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.4-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

ТАЙЛБАР: Эдгээр шаардлага нь олон улсын ISO 19157 стандартад заасан чанарын үзүүлэлтүүд юм. Энэхүү дурдсан ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөх нь олон улсын хэмжээний нэгдсэн үзүүлэлттэй байх зарчимд нийцдэг.

4.5.2 Газар зүйн нэрийн суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 “Бүрэн бүтэн байдал”-ыг хангах шаардлага болох өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объектын төрлийн түвшнээс илүү гарах эсвэл дутахгүй байх шаардлагатай.

4.5.2.2 “Утга агуулгын нийцтэй байдал”-ыг хангах шаардлага болох өгөгдлийн багц, орон зайн объект, орон зайн объектын төрлийн түвшинд ойлголт, домэйн, формат, топологийн алдаагүй, утга агуулгын хувьд нийцтэй байна.

4.5.2.3 “Байрлалын нарийвчлал”-ыг хангах шаардлага болох орон зайн объектын байршлын нарийвчлалын түвшин байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Газар зүйн нэрийн орон зайн суурь өгөгдлийн багц ба ангилал

А.1.1 Өгөгдлийн багц: Geographical names (Газар зүйн нэр)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Газар зүйн нэрийн объект <i>/Named place/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун, полигон, цэг	Газрын гадарга дээр орших газар нутаг болон газар зүйн объектыг нэрлэж, байнга хэрэглэж хэвшсэн нэр.
2	Газар зүйн нэр <i>/Geographical name/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Газар зүйн нэр.
3	Тодруулга, судалгаа хийсэн хуулийн этгээд <i>/Operator name/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Газар зүйн нэрийн тодруулга, судалгааны ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгж болон инженерийн нэр, албан тушаал.
4	Батлагдсан шийдвэр <i>/Official document/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Эрх бүхий байгууллагаас газар зүйн нэрийг баталсан шийдвэрийн мэдээлэл.
5	Дүрслэгдэх хамгийн бага нарийвчлал <i>/Least detailed view resolution value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын доод утга.
6	Дүрслэгдэх хамгийн их нарийвчлал <i>/Most detailed view resolution value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн том масштабын утга.
7	Үндсэн ангилал <i>/Major class value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар зүйн нэрийн хамаарах орон зайн объектын ангилал.
8	Дэд ангилал <i>/Medium class value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар зүйн нэрийн үндсэн ангиллын дотоод ялгарал.
9	Анхдагч ангилал <i>/Minor class value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газар зүйн нэрийн дэд ангийн дэвсгэр нэрээр ялгагдах дотоод анги.
10	Газар зүйн нэрийн объектын ангилал <i>/Named place type value/</i>	«кодын жагсаалт»	Ангилал	Газрын зургийн үндсэн болон сэдэвчилсэн агуулгаар ангилсан газар зүйн нэрийн ангилал.

		«code list»		
11	Газар зүйн нэрийн төлөв <i>/Name status value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тухайн газар зүйн нэрийн батлагдсан эсэх төлөв.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга**А.2.1 Өгөгдлийн багц – Газар зүйн нэр (Geographical names)****А.2.1.1 Биет төрлийн нэр: Газар зүйн нэрийн объект (Named place)**

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	Дотоод танигч /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг өөрчилсөн /эсхүл засварласан/ эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.

7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date/	Огноо /Date time/	25	Үзэгдэл (газар зүйн объект) бодит байдалд оршин тогтнож эхэлсэн үе.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date/	Огноо /Date time/	25	Үзэгдэл (газар зүйн объект) бодит байдалд оршихгүй болсон үе.
9	Дүрслэх хамгийн бага нарийвчлал /Least detailed view resolution/	Дүрслэх хамгийн бага нарийвчлал /Least detailed view resolution value/	-	-	Газрын зурагт дүрслэгдэх газар зүйн нэрийн масштабын хязгаарын доод утга. Least detailed view resolution value - ийн утгуудаас авна.
10	Дүрслэх хамгийн их нарийвчлал /Most detailed view resolution/	Дүрслэх хамгийн их нарийвчлал /Most detailed view resolution value/	-	-	Газрын зурагт дүрслэгдэх газар зүйн нэрийн масштабын хязгаарын доод утга. Most detailed view resolution value - ийн утгуудаас авна.
11	Үндсэн ангилал /Major class type/	Үндсэн ангилал /Major class value/	-	-	Газар зүйн нэрийн байгалийн болон хүний буй болгосон байдлаар нь ангилсан үндсэн ангилал. Major class value (Үндсэн ангилал)-ын утгуудаас авна.
12	Дэд ангилал /Medium class type/	Дэд ангилал /Medium class value/	-	-	Газар зүйн нэрийн төрлөөр ялгагдах дэд ангилал. Medium class value (Дэд ангилал)-ын утгуудаас авна.
13	Анхдагч ангилал /Minor class type/	Анхдагч ангилал /Minor class value/	-	-	Газар зүйн нэрийн дэвсгэр нэрээр ялгагдах анхдагч ангилал. Minor class value (Анхдагч ангилал)-ын утгуудаас авна.
14	Нэр /Name/	«Газар зүйн нэр» «GeographicalName»	-	-	Газар зүйн нэр, нэртэй холбоотой атрибут агуулсан өгөгдөл төрөл.
15	Газар зүйн нэрийн объект /Type/	Газар зүйн нэрийн объектын ангилал /Named place type value/	-	-	Газар зүйн нэрийн ангилал. Named place type value ангиллын утгуудаас авна.

16	Тодруулга, судалгаа хийсэн хуулийн этгээд /Operator name/	«Тодруулга, судалгаа хийсэн хуулийн этгээд» «Operator name»	-	-	Газар зүйн нэрийн тодруулга, судалгааны ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж болон инженерийн нэр, албан тушаал
17	Батлагдсан шийдвэр /Official document/	«Батлагдсан шийдвэр» «Official document»	-	-	Эрх бүхий байгууллагаас газар зүйн нэрийг баталсан шийдвэрийн мэдээлэл.

А.2.1.2 Өгөгдөл төрлийн нэр: Газар зүйн нэр (Geographical name)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Хэл /Language/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	ISO 639-3 эсвэл ISO 639-5 стандартын дагуу гурван үсэгтэй код хэлбэрээр өгөгдсөн оноосон газар зүйн нэрийн хэл.
2	Бичвэр /Text/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Газар зүйн нэр.
3	Үсгийн хэлбэр /Script/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Нэрийг бичихдээ ISO15924-д тодорхойлсон дөрвөн үсгийн кодыг ашиглан илэрхийлсэн график тэмдгүүдийн багц.
4	Галигчлал /Transliteration/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Газар зүйн нэрийн латин галиг.
5	Галигчлалын стандарт /Transliteration standart/	Холбоос /URL/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	MNS 5217: 2012 стандартын дагуу бичнэ.
6	Газар зүйн нэрийн төлөв /Name status/	Газар зүйн нэрийн төлөв /Name status value/	-	-	Газар зүйн нэр батлагдсан эсэхийг ангилсан ангилал. Name status value ангиллын утгуудаас авна.

А.2.1.3 Өгөгдөл төрлийн нэр: Тодруулга, судалгаа хийсэн хуулийн этгээд (Operator name)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Аж ахуйн нэгжийн нэр /Organization name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Хэмжилт тодруулалт хийсэн аж ахуйн нэгжийн нэр.
2	Ажилтны нэр	Тэмдэгтийн мөр	Тэмдэгтийн мөр	50	Хэмжилт тодруулалт хийсэн ажилтны нэр.

	/Name of employee/	/Character string/	/Character string/		
3	Ажилтны албан тушаал /Employee position/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Хэмжилт тодруулалт хийсэн ажилтны албан тушаал.
4	Газарчны нэр /Guide name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Газар нутаг, хил, зааг, газар усны нэр сайн мэддэг нутгийн газарчны нэр.
5	Бүртгэсэн огноо /Date/	Огноо /Date/	Огноо /Date time/	20	Хэмжилт тодруулга, судалгаа хийсэн огноо.

А.2.1.4 Өгөгдөл төрлийн нэр: Батлагдсан шийдвэр (Official document)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Шийдвэрийн нэр /Document name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Тухайн Газар зүйн элементийн нэрийг баталгаажуулсан шийдвэрийн нэр.
2	Шийдвэрийн дугаар /Document number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Тухайн Газар зүйн элементийн нэрийг баталгаажуулсан шийдвэрийн дугаар.
3	Шийдвэрийн огноо /Document date/	Огноо /Date/	Огноо /Date time/	70	Тухайн Газар зүйн элементийн нэрийг баталгаажуулсан шийдвэрийн огноо.

В хавсралт
(норматив)

Кодын жагсаалт

В.1 Өгөгдлийн багц – Газар зүйн нэр (Geographical names)

В.1.1 Дүрслэх хамгийн бага нарийвчлал - Least detailed view resolution value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	1:500	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
2	1:1000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
3	1:5000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
4	1:10000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
5	1:25000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
6	1:50000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
7	1:100000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
8	1:500000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
9	1:1000000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
10	1:2500000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга
11	1:12000000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын доод утга

В.1.2 Дүрслэх хамгийн их нарийвчлал - Most detailed view resolution value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	1:500	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын дээд утга
2	1:1000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын дээд утга
3	1:5000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын дээд утга
4	1:10000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын дээд утга
5	1:25000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын дээд утга
6	1:100000	Газар зүйн нэрийн үзүүлэгдэх газрын зургийн масштабын хязгаарын дээд утга

В.1.3 Үндсэн ангилал – Major class value

Д/д	Үндсэн ангиллын код	Үндсэн ангилал	Тодорхойлолт
1	Н	Засаг захиргаа (administration)	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж
2	В	Байгаль (nature)	Газар зүйн үндсэн элементүүд, байгалийн тогтоц
3	Ү	Хүний бүтээсэн (manMadeObject)	Хүний гараар бүтээгдсэн элементүүд

В.1.4 Дэд ангилал – Medium class value

Д/д	Дэд ангиллын код	Дэд ангилал	Үндсэн ангилал
1	Н01	Засаг захиргааны нэгж (administrativeUnit) . Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийн нэгжийн нэр.	Засаг захиргаа /administration/
2	Н02	Суурьшил (settlement) . Хот байгуулалтын нэгж болох хот, дүүрэг, хороо, хороолол, хотхон	
3	В01	Уул зүй (mountain) . Газрын гадаргын хэлбэр дүрсийг ялгарлыг харуулах дэд ангийн нэр.	Байгаль /nature/
4	В02	Амьтан, ургамал (animal, plant) . Газар зүйн нэрийн дэвсгэр нь амьтан ургамлын нэрээр нэрлэгдсэн дэд ангийн нэр	
5	В03	Хөрс, чулуулаг (soil, geology) Байгалийн тогтоц, газрын гадаргын төрх байдлаараа онцлог газрын нэрээр нэрлэгдсэн газар зүйн нэрийн дэд ангийн нэр.	
6	В04	Ус зүй (hydrography) . Гол, мөрөн, нуур, цөөрөм, горхи, худаг, рашаан, булаг, шанд, усан сан, мөсөн гол зэргийг нэрлэсэн газар зүйн нэрийн дэд ангийн нэр.	
7	В05	Зүг чиг, байршил (direction) . Газар зүйн нэрийн дэвсгэр нэрд тодорхой, чиглэл, байршил заасан утга бүхий нэрийн анги	
8	В06	Уур амьсгал (climate) . Газар зүйн нэрийн дэвсгэр нэрд уур амьсгал, байгалийн үзэгдлийг заасан утга бүхий нэрийн анги.	
9	В07	Тогтоц (landform) . Байгалийн жамаар бүрэлдэн цогцолсон хэв маяг, төрх элдэв тогтцын ялгарлыг харуулсан анги.	
10	Ү01	Түүхэн, дурсгалт (historicalMonuments) . Хүний гараар бүтээгдэн бий болсон эртний булш, бунхан, хиргисүүр, хөшөө чулуу, хадны сүг зураг, сүм хийдийн туурь зэргийн нэрийн анги.	Хүний бүтээсэн /manMadeObject/
11	Ү02	Барилга, байгууламж (buildings) . Хүний гараар бүтээгдсэн бүх барилга байгууламжуудын нэрийн анги	
12	Ү03	Шашин (religion) . Үзэл, номлол, шүтлэг бишрэлийн гаралтай шашны барилга байгууламжийн ерөнхий нэрийн анги.	

В.1.5 Анхдагч ангилал – Minor class value

Д/д	Анхдагч ангиллын код	Анхдагч ангилал	Дэд ангилал	Үндсэн ангилал
1	H0101	Нийслэл (niislel). Улсын нийслэл хотын нэр	Засаг захиргааны нэгж /administrativeUnit/	Засаг захиргаа /administration/
2	H0102	Аймаг (aimag). Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр.		
3	H0103	Дүүрэг (dүүreg). Нийслэл, томоохон хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр		
4	H0104	Сум (sum). Аймгийн дараах засаг захиргааны нэгжийн нэр.		
5	H0105	Хороо (khoroo). Хот суурин газрын засаг захиргааны анхан шатны нэгжийн нэр.		
6	H0106	Баг (bag). Орон нутгийн засаг захиргааны хамгийн бага нэгжийн нэрж.		
7	H0107	Тосгон (tosgon). Тосгон нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар.		
8	H0201	Суурин (suurin). Нэгэн газар барилга байшин цогцлон суурьшсан бөгөөд үйлдвэр, худалдаа төвлөрч хүн ам олноор төвлөрсөн газар	Суурьшил /settlement/	
9	H0202	Гудамж (gudamj). Эгнэсэн хашаа барилга түүний завсрын шулуун чөлөө		
10	H0203	Талбай (talbai). Хот суурин газар тусгай зориулалтаар хийгдсэн талбайн нэр		
11	H0204	Хороолол (khoroolol). Нийтийн орон сууц болон хүүхдийн цэцэрлэг, сургууль, эмнэлэг, дэлгүүр зэрэг үйлчилгээний цогцолбор бүхий бичил хотхоны нэр		
12	H0205	Хотхон (khotkhon). Хотын доторх болон хот орчмын жижиг суурин, багахан хотхоны нэр		
13	H0206	Өртөө (ürtüü). Галт тэрэг, машин тэрэг түр зогсох, дамжин өнгөрөх газар, албаны хүмүүс, албан зар, бичиг зэргийг дамжуулах өнгөрүүлэх, хүргэх морин хөсөгтэй буудлын газрын нэр		
14	H0207	brigad (Бригад). Хэд хэдэн хороо цэргээс бүрддэг цэргийн байгуулалт, нэг төрлийн үйлдвэрлэл, ажил төрөл эрхэлдэг бүлэг		
15	H0208	tasag (Tacar). Албан газар, нэгж байгууллага, үйлдвэрийн газрын дотоод хуваарь, хэсэг		
16	H0209	Ферм (fyerm). хөдөө аж ахуйн төрөлжсөн жижиг нэгж.		

17	H0210	Аймгийн төв (aimag). Газар зүйн тодорхой орон зай эзлэн нутгийн хил зааг нь газар зүйн нэрээр хязгаарлагдан орших нутаг дэвсгэртэй засаг захиргааны нэгж.		
18	H0211	Сумын төв (soum). сумын захиргаа, эмнэлэг, сургууль үйлчилгээ төвлөрсөн суурин		
19	H0212	Багийн төв (bag). Орон нутгийн засаг захиргааны хамгийн бага нэгж		
20	H0213	Хороо (khoroo). Хот суурин газрын засаг захиргааны анхан шатны нэгж		
21	B0101	Аараг (aarag). Жалга судгаар хэрчигдсэн, хад сархиаг ихтэй толгодлог газар	Уул /mountain/	Байгаль /nature/
22	B0102	Адарга (adarga). Газрын гадаргын атираа, нугачаа, үелсэн намхан толгодын нэр		
23	B0103	Ам (am). Уул, нурууны салбарласан өндөр хянга, хамруудын хооронд орших хавчиг хөндий		
24	B0104	Асга (asga). Уул, хавцал зэрэг газарт хэсэг хэсгээр овооролдон орших сул хад чулууны нэр		
25	B0105	Байц (baits). Уулархаг нутагт тусгайдуу орших харьцангуй өндөр эгц хадан халил, бэрх газар.		
26	B0106	Богоч (bogoch). Уулын онийг бодвол тавиун, зорчих боломжтой багахан хөтөл.		
27	B0107	Бөөрөг (böörög). Олон жилийн цэвдгийн бүсэд тохиолдох сууриараа 5-300 метр хүрэх, 20-40 метр өндөртэй товгор газар. Говь цөлийн бүсэд тохиолдох ургамалжсан элсэн ухаа, толгод.		
28	B0108	Бэл (bel). Уулын хормойгоос доош хотгорын ёроол хүртэлх уудам хэвгий газар.		
29	B0109	Даваа, дав, онь (davaa, dav, oni). Замд хөндөлсөх өндөр агаад давахад хэцүү, бартаа бүхий нуруу газрын нэр		
30	B0110	Дөрөлж (dörölj). Уулархаг, хад чулуурхаг газрын нам хөтөл.		
31	B0111	Ёроол (yoroöl). Уулын хажуу бэл: Уулын ёроолын нэр		
32	B0112	Зоо (zoo). Уудам, гүдгэр газар: Уулын зоо (уулын оройн гүдгэр хэсэг), зоо дэлийн нэр		
33	B0113	Зураа (zuraa). Уул нуруунаас доош салбарласан нарийн урт гүдгэр газар: Уулын зурааны нэр		
34	B0114	Зээг (zeeg). Тодорхой хэсэг газрыг эмжин тогтсон хад чулуу бүхий газар.		
35	B0115	Нуруу (nuruu). Уулын урт зоо болон үргэлжилсэн уулсын нэр		

36	B0116	Овоо (ovoo). Шүтлэгийн зориулалтаар уул, даваа, тал дээр болон хил хязгаарын зааг тэмдэг болгон овоолж босгосон мод чулуу.
37	B0117	Орой, оргил, өндөрлөг, өндөр (oroï, orgil, öndörlög, öndör). Уулын ноён орой, дээд тал, уул толгой, даваа гүвээний хамгийн өндөр хэсэг
38	B0118	Өвөр (övör). Уулын энгэр, нөмөр хэсэг
39	B0120	Сархиа, сархиаг, сархид (sarkhia, sarkhiag, sarkhid). Олон гүнзгий гуу жалга, хад асга, нугачаатай, энхэл донхол, хотгор гүдгэр газар
40	B0121	Сарьдаг (saridag). Мөнх цаст уул, өндөр гозгор орой бүхий уул
41	B0122	Суга (suga). Уулын хажуугийн завсар
42	B0123	Сэрвэн (serven). Уулын сэрвэгэр сэртгэр хэсэг
43	B0124	Таг (tag). Уулын тэгш орой: Тагийн бүс (өндөр уулын бүс)
44	B0125	Тайга (taiga). Хөндөгдөөгүй ой хөвч бүрхсэн өтгөн шигүү, өндөр аглаг уул нуруу
45	B0126	Толгод (tolgod). суурь чулуулгийн гадаад хүчний нөлөөгөөр элэгдэн хэсэгчлэгдэх явцад үүссэн олон жижиг толгой.
46	B0127	Толгой, болдог (tolgoi, boldog). Суурь чулуулгийн гадаад хүчний нөлөөгөөр элэгдэн үүссэн тусгайдуу орших 10-100 м харьцах өндөртэй гадаргын гүдгэр. хэлбэр бүхий газар.
47	B0128	Уул, хайрхан (uul, khairkhan). Эргэн тойрны орчноос онцгойрон ялгарч, оргил, нуруу хэлбэрээр хоёр зуун метрээс дээш өргөгдсөн газрын гадарга
48	B0129	Ухаа (ukhaa). ихэвчлэн талархаг нутагт тархсан намхан, ялимгүй сунгуу, 10-30 метр харьцах өндөртэй гүдгэр газар.
49	B0130	Хавцал (khavtsal). Тектоник хагарлын дагуу болон урсгал усны үйл ажиллагаагаар үүссэн эгц хадан хана, шаварлаг хурдас бүхий нарийн зурвас газар.
50	B0131	Хамар, өвдөг, гээг (khamar, övdög, gezeg). Үргэлжилсэн уулын хяр, хөтөл: Хамар давах
51	B0132	Хормой (khormoi). Уулын бэлийн доод этгээдийн газар: Уулын хормой
52	B0133	Хунх, хүнх (khunkh, khünkh). Хонхор газар (нам дор газар)
53	B0134	Хүнхэр (khünkher). Хонхор газар (нам дор газар)
54	B0135	Хүр, хүрд (khür, khüрд). Хонхор газар (нам дор газар)
55	B0136	Хэц (khets). Уул нуруу, хад асгын цавчим өндөр, огцом налуу газар

56	B0137	Хяр, хянга (khyar, khyanga). Өндөрлөг уулс, нуруудын дээд ирмэг, хянга	
57	B0138	Хясаа (khyasaa). Уулын халилын ирмэг, усны захын эргэцэг мэт явах зорчиход бэрх хэцүү эгц өндөр хадан хавцал	
58	B0139	Цав (tsav). Уулын хоёр талын жигүүрийн өндөр газар	
59	B0140	Царам (tsaram). Уулын хяр, хөндий, хоолой, хөвч мэтийн өндөр газарт жавар, сэрүүн хялбар тусах газар	
60	B0141	Шил (shil). Дундаж ба нам уулсын бүсэд хэсэгхэн сэрвэн хад бүхий бөмбөгөрдүү оройтой сунаж тогтсон нуруу.	
61	B0142	Энгэр, ташуу, цалуу, нураг, нурган, нахиу (enger, tashuu, tsaluu, nurag, nurgan, nakhiu). Уулын наран өвөр тал, уулын нөмөр хэсэг, налуу хэсэг	
62	B0143	Ангалаг, анталаг (angalag, antalag) Газрын гадаргад үүссэн ан цав бүхий газрын нэр	
63	B0201	Айраг (airag). Нэгэн төрлийн ургамал	Амьтан, ургамал /animal, plant/
64	B0202	Бургас, бут, бударгана, бураа, арц, сондуул, торлог, хармаг, сухай (burgas, but, budargana, buraa, arts, sonduul, torlog, kharmag, sukhai). Бутлан ургадаг сөөглөг ургамал	
65	B0203	Дэрс (ders). Үет ургамлын язгуур; сайр нуга, хээр тал, хужирлаг цайдамд ургадаг, хавтгай урт навчтай, хатуу нарийн иштэй, буталж ургадаг олон наст өвс	
66	B0204	Заг (zag). Говь газар ургадаг, цагаан дурстай, хайрслал чатган навчтай, найлзуур нь шилмүүсний хэлбэртэй, буурцгийн дотоодод цагариг ногоон үртэй, яслал хатуу нэг зүйл мод	
67	B0205	Мод (mod). Ихэвчлэн ганц нэг буюу хэсэг бүлэг төгөл бус модтой газар.	
68	B0206	Нарс (nars). Бөөрөнхий боргоцойтой, мөнх ногоон, урт хос шилмүүстэй нэгэн зүйл мод	
69	B0207	Нуга, ширэг, зүлэг, таана (nuga, shireg, zuleg, taana). Голын хөвөө дагуу болон уул нуруу, даваа гүвээ зэрэг газрын хөндий дэх чийг ихтэй өвс, ногоо сайн ургадаг булан тохой	
70	B0208	Ой, төгөл, хөвч (oi, tögöl, khövch). Шилмүүст, навчит мод, төгөл арвин газар болон ойгоос тусгайдуу орших, бөөндүү шигүүвтэр ургасан хэсэг модод бүхий газар	
71	B0209	Сөөг, шаваг, шарилж (söög, shavag, sharilj). Бутлан ургасан ургамлын нэг төрөл бүхий газар	
72	B0210	Түнгэ, ширэнгэ, шугай (tünge, shirenge, shugai). Чигжүү ургасан мод сөөг, ой дотор нягт шигүү ургасан мод	
73	B0211	Тэсэг (teseg). Луультан овгийн гучаас тавин сантиметр орчим өндөр, ёзоороосоо олон салаалсан иштэй, үслэг цайвар	

MNS 6925-3 : 2021

		навчтай, өвөл хаврын цагт малд тэжээлтэй, говь хээрийн бүсэд бутаар ургадаг заримдаг сөөгөнцөр	
74	B0212	Улиас (ulias) . Бургастан овгийн навчит мод. Нэг төрлийн навчит мод, түүгээр нэрлэгдэх газар.	
75	B0213	Хаг (khag) . Хад чулуу, мод хөрсний гадарга дээр ургах мөөг замгаас тогтох симбиоз амьдралтай доод ургамал, түүгээр нэрлэгдэх газар.	
76	B0214	Хайлаас, хайлс (khailaas, khails) . Хээр, говийн бүсэд ихэвчлэн элс болон хуурай сайр дагуу тохиолдох нэгэн зүйл навчит мод, түүгээр нэрлэгдэх газар.ы	
77	B0215	Харгайт (khargait) . Гацууртай адил болоод яс чийрэг, чанар хүнд, дурс зузаан, уул хөвчийн чийглэг жихүүн газарт ургадаг нэгэн зүйл мод	
78	B0216	Харгана (khargana) . Буурцагтан овгийн төрөл, модлог сөөг ная орчим зүйлтэй.	
79	B0217	Хулс (khuls) . Усны хөвөөгөөр ургадаг, сүрэл нь хөндий, гялгар, хавтга шөвөг хэлбэрт навчтай, цэцэг нь бор, доод талдаа олон ширхэг шиг үстэй, сүрлээр нь чийрс гөрөх буюу цаас хийдэг олон наст өвс	
80	B0218	Хус, боролж (khus, borolj) . Гол мөрний хөндий болон ус чийг элбэр газар ургах нэгэн зүйл навчит мод, түүгээр нэрлэгдэх газар.	
81	B0219	Шинэс (shines) . Хангай, ой тайгад ургадаг нэг зүйл шилмүүст мод, харгай ч гэж нэрэлдэг. Түүгээр нэрлэгдэх газар.	
82	B0301	Марз, мараа (marz, maraa) . Мал гөрөөсний идэх мараа хужир, шорвог эрдэстэй газар	Хөрс, чулуулаг /soil, geology/
83	B0302	Намаг (namag) . Зүлэг шавартай нойтон, чийгтэй бамбалзуур газар, ургамлын өвөрмөц бүрхэвчтэй, ихэнхдээ хүлэр агуулсан, хэт чийгшилтэй хуурай газрын хэсэг	
84	B0303	Сондог (sondog) . 3-5 метр өндөр бүхий сухайн бутнууд элс барьж тогтсоноос үүссэн овгор хуримтлал буюу бут ургасан наанги хөрстэй дов	
85	B0304	Хайрга, дайрга (khairga, dairga) . Голын усаар угаагдаж мөлийсөн нэн үйрмэг чулуу	
86	B0305	Хаш, хүлэр, зэс (khash, khüler, zes) . Ашигт малтмал	
87	B0306	Чулуу (chuluu) . Байгалийн үлэмж их нягтарсан, олон улсын хөрс судлалын нийгэмлэгийн ангиллаар 2 миллиметрээс дээш голчтой хатуу эрдэс чулуулаг	
88	B0307	Шал, шавар, шалбааг, лах (shal, shavar, shalbaag, lakh) . Намаг, шавхай	

89	B0308	Элс, манхан (els, mankhan). Янз бүрийн гарал үүсэл, найрлагатай хурдас чулуулгийн эвдрэл, өгөршлөөс үүссэн жижиг мөхлөгтэй чулуу, олон улсын хөрс судлалын нийгэмлэгийн ангиллаар хоёр миллиметр хүртэлх голчтой жижиг хэсэг	Ус зүй /hydrography/
90	B0309	Явар, цахир, цайдам, борзон (yavar, tsakhir, tsaidam, borzon). Бүдүүн мөхлөгт, барьцалдсан бат бэх цахиурлаг, хайрганцар чулуу	
91	B0401	Арал (aral). Нуур далай, гол мөрөн доторх бүх талаараа усаар хүрээлэгдсэн хуурай газар, ойрад нэг зүйлийн зэрлэг жимс, хүн, амьтны нуруу, өндөр	
92	B0402	Боом (boom). Голын усны урсгалыг хавчиж нарийсан зорчиход бэрхшээлтэй болсон газар.	
93	B0403	Булаг (bulag). Газрын гүнээс болон хөрснөөс ундран гарч урсах ус.	
94	B0404	Гарам, олом (garam, olom). Мөрөн голын усыг уналга хөсөг юм уу хөлөг онгоц тэргүүтнээр гатлах тавилан газар	
95	B0405	Гаталга (gatalga). Гол мөрөн гатлах хөвүүр гүүр байрладаг газар	
96	B0406	Гол, харз (gol, kharz). Газрын доорх болон хөрсний уснаас эх авч өөрийн голдирол саваар байнга урсах байгалийн урсгал ус	
97	B0407	Горхи (gorkhi). Голоос хэмжээгээр бага тогтмол урсацтай гадаргын ус.	
98	B0408	Мөрөн (mörön). Олон голууд нийлэн цааш их усанд цутгах том гол.	
99	B0409	Нуур (nuur). Тухайн газрынхаа нам түвшинд байрлах, гүний болон гол мөрний усаар тэжээгдэх, хуурай газрын томоохон тогтмол ус.	
100	B0410	Рашаан (rashaan). Газрын гадаргад ундран гарах халуун, хүйтэн эрдэст устай газар.	
101	B0411	Сайр, садарга (sair, sadarga). Гол, мөрний ус салбарлан урсах голдирол: Мөрний садарга, жалга сархиаг ихтэй газар: Сайр садарга	
102	B0412	Салаа (salaа). Уулын зэрэгцээ байрлалтай амуудыг ялгаж нэрлэхийн зэрэгцээ том голоос салж нийлсэн жижиг голдирол.	
103	B0413	Суваг, судаг, татаал (suvag, sudag, tataal). Ус урсах зорилгоор бий болгосон голдирол, шуудуу бүхий байгууламж болон тогтмол бус урсцаас үүсэлтэй нарийн ховил жалга газар	
104	B0414	Тавилан (tavilan). Хуурай газрын тээврийн хэрэгсэл, ачаа, зорчигчдыг тээвэрлэн ус гаталгах хөвөгч байгууламж, мөрөн голын гарц, гарам, олом	

MNS 6925-3 : 2021

105	B0415	Татуурга (tatuurga). Их мөрөн, голоос салаалан урсаж байгаад буцан нийлэх байнгын устай нарийн гол.	
106	B0416	Тойром, цөөрөм (toirom, tsööröm). Хур элбэгтэй цагт нуур болж, ус бороо ховор цагт шавар шалбааг болох буюу бүр хатаж хуурайшдаг хужирлаг шороо бүхий халцгай, хонхор газар	
107	B0417	Тохой (tokhoi). Гол, горхи тахирлан дугуйрч, урсгал нь саарсан газар.	
108	B0418	Ус (us). Булаг шанд, рашаан болон цавчаал ус, гар худаг бүхий газар.	
109	B0419	Усан сан (usanSan). Усыг нөөцөлж нийтэд түгээх газар, ус хуримтлуулан хашсан цөөрөм	
110	B0420	Хөвөө (khövöö). Далай, тэнгис, нуур, гол, мөрний зах, хязгаар	
111	B0421	Худаг (khudag). Газар доорх усыг хүн малд зориулан гаргасан байгууламж бүхий газар.	
112	B0422	Цутгалан, хүрхрээ, таргил (tsutgalan, khürkhree, targil). Гол мөрнүүдийн, нуур, далай тэнгист хажуугаас нь цутган орж, нийлж байгаа газар, хэц өндөр, хавцал газраас доош цочмог ширүүн цутган буух ус	
113	B0423	Цүнхэг, цүлхэн, хөв (tsünkheg, tsülkhen, khöv). Уулархаг нутгийн ёроолд болон гадаргын нам түвшинд ус цуглуулах байгалийн гаралтай болоод зориудаар далан хаалт босгож байгуулсан байгууламж, түүгээр нэрлэгдэх газар.	
114	B0424	Шанд (shand). Хээр, говь цөлийн бүсэд орших хол урсдаггүй бяцхан булаг.	
115	B0425	Баянбүрд (bayanbürd). Говь цөл нутгийн дунд орших булаг шандыг даган үүссэн өвөрмөц экосистем, өтгөн шигүү өвс ургамал, зүлэг, ширэг, мод, бут сөөг бүхий газар.	
116	B0501	Адаг (adag). Уулын болон гол мөрний төгсгөл, хуурай голдирол, сайр хөндийн шувтарга хэсэг.	Зүг чиг, байршил /direction/
117	B0502	Ар (ar). Уул, нуруудын сүүдэрлэг хажуу, түүнчлэн хойд талд нь орших газар нутаг.	
118	B0503	Булан (bulan). Гол, мөрний тахирлан тохойрох хэсэг газар.	
119	B0504	Бэлчир (belchir). Уул, гол мөрөн, зам болон өөр нэр бүхий газар нутгийн нийлэх зааг уулзвар газар.	
120	B0505	Ганга (ganga). Уул толгодын завсар, гуу жалга, цас борооны усанд идэгдэн гарсан суваг	
121	B0506	Говь (govi). Ургамал тачир сийрэг, ой мод ба урсгал ус маш ховор, элс хайрган хөрстэй, тарвага нутагшдаггүй, хээр тал газар	

122	B0507	Гүвээ, гүдгэр, гүдэн, гүрдгэр (güvee, güdger, güden, gürdger). Хотгор гэдгийн эсрэг утга, төвгөр, товгор	
123	B0508	Дов, довон, довцог (dov, dovon, dovtsog). 10 метр хүртэлх харьцах өндөртэй зөв бөмбөгөр хэлбэртэй, энхэл донхол, бартаа ихтэй бэсрэг товгор газар, говийн бүсэд хармаг, харгана зэрэгт хурж тогтсон элсний хэлбэр	
124	B0509	Дэл (del). Эгц хянга оройтой хад чулуурхаг богиновтор нуруу.	
125	B0510	Зааг (zaag). Газар зүйн хоёр биетийн хил нийлсэн болон эсвэл нэг биетийн дундуур гарсан завсар чөлөө.	
126	B0511	Завсар (zavsar). Алив юмны хоорондох зай болон хоёр уулын хооронд орших хотгор газар.	
127	B0512	Зах (zakh). Газар нутаг, орон байр, талбай зэрэг зүйлийн хөвөө, ирмэг хязгаар	
128	B0517	Нүүр (nüür). Уул, нурууны болон Газар зүйн биетийн өвөр тал.	
129	B0513	Урт (urt). Эртний голын хөндий зэрэг гадаргын аливаа хэлбэр сунасан байдлаар үргэлжлэх газар.	
130	B0514	Уулзвар (uulzvar). Хоёр биетийн уулзах хил залгах сайр, зам, хөндий, ам, голын нийлсэн газар	
131	B0515	Үзүүр (üzüür). Уул нуруудын намссан шувтрах хэсэгт орших нарийн хамар.	
132	B0516	Хаяа (khayaa). Янз бүрийн тогтоцтой газрын зах, хөвөө, хязгаар	
133	B0518	Эх, эхэн (ekh, ekhen). Аливаа газар зүйн элементийн анх үүсгэл, эхлэл: Голын эх	
134	B0602	Зэрэглээ (zereglee). Газрын уур дээш хөөрч хөх униар дэгдсэнээс алсын зүйл усны дүр адил харагдах үзэгдэл ба говь, талархаг нутгийн зэрэгцээ олон нугачаа бүхий өндөрлөг газар.	Уур амьсгал /climate/
135	B0603	Уур (uur). Байдал уулын орой тагтад үүссэн жижиг хунх, хотос мөн цаг агаарын нөхцөл,	
136	B0604	Хур (khur). Агаар мандалд үүл болон хөөрсөн усны уур хүйтэн агаарын нөлөөгөөр шингэн, хатуу хэлбэрт шилжин хуримтлагдаж доош буух	
137	B0701	Агуй, хонгил (agui, khongil). Газрын гүнд болон хад чулуунд үүссэн, янз бүрийн хэлбэр хэмжээтэй, орох гарах амтай хөндий нүх, хонгил.	Тогтоц /landform/
138	B0702	Ан, ангал, гануу (an, angal, ganuu). Хад, газар зэрэг хагаран ангайж гүнзгий ан цав гарсан газар	
139	B0703	Барзан (barzan). Уул хадны арзгар сэрвэн ихтэй байдал	

MNS 6925-3 : 2021

140	B0704	Бүрд (bүрд). Гүний усны тэжээлтэй, багахан зайд урсах горхи бүхий газар
141	B0705	Гацаа, сүв, мухар (gatsaa, сүв, mukhar). Алс буйд, хол: Газрын мухар, юмны битүү булан: Мухар гудамж (нэвт гарах боломжгүй битүү гудамж)
142	B0706	Гозгор, шовх, шовгор (gozgor, shovkh, shovgor). Дээш нарийссан үзүүртэй сэрвэн хад цохио бүхий газар болон тусгайдуу, ганц шовх уул.
143	B0707	Дэнж, дэвсэг, дэв, хавтгай, ширээ (denj, devseg, dev, khavtgai, shiree). Гол мөрөн, нуурын усны эрэг дагаж шаталсан байдлаар тогтсон гадаргын гүдгэр хэлбэр болон уулын бэл ам хөндийн адаг орчмын гол, горхинд тулсан орчноосоо өндөрхөн багавтар тэгшивтэр газар.
144	B0708	Жалга, гуу, зуух (jalga, guu, zuukh). Цас, борооны ус урсаж тогтсон хонхор нарийн зурвас газар, том, жижиг гуу
145	B0709	Мөргөцөг, мөргүү, мөрөг, ирмэг, хөмөг (mörgötsög, mörgүй, mörög, irmeg, khömög). Эрэг жалга бүхий газрын ирмэг зах, аливаа усан сан, голын зүгээс байрлалтай, дэнжийг хязгаарласан хажуу болон тохойрсон газрын эргэцэг
146	B0710	Овгор, товгор, товог, дүмбэн, оорцог (ovgor, tovgor, tovog, dümben, oortsog). Овгор, төмбөгөр
147	B0711	Огторго (ogtorgo). Тектоник хөдөлгөөнөөр уулын чулуулаг тасарч шилжин зөрөгт өргөгдөл, ховдол үүсгэсэн газар
148	B0712	Тал (tal). Харьцангуй тэгш гадаргатай өвслөг ургамал бүхий өргөн уул даваа, хотгор гүдгэр зэрэг өндрийн хэлбэлзэл бага, уудам тэгш газар
149	B0713	Тэнгэр (tenger). Газрын дээд хэсэгт байх бидний нүднээ үзэгдэх агаар мандал, шүтлэг бүхий газар
150	B0714	Тээг (teeg). Ам хөндий, зорчих замд хөндөлсөн байрлах хад чулуу болон эгц хажуутай гүдгэр газар.
151	B0715	Хад, цохио, цонж (khad, tsohio, tsonj). Уулархаг нутаг болон голын хөндийд онцгойдуу харагдах өндөр хад
152	B0716	Ханан (khanan). Эгц босоо саад, хад чулуу бүхий газар
153	B0717	Ховол (khovol). Уртаашаа сунасан нарийн хонхор газар
154	B0718	Хонд (khond). Айл өвөлжөөлөх, хаваржаанд буух завсарт цөөн хоног буудаллах нөмөр нөөлөгтэй бууц бүхий газар
155	B0719	Хонхор, хонх, хунхуй (khonkhor, khonkh, khunkhui). Багахан хэмжээтэй хотгор газар
156	B0720	Хоолой (khooloi). Хоёр уулын хоорондох өргөн тавиу газар, хоёр нуурыг холбосон горхи суваг

157	B0721	Хорголж (khorgolj). Бөөрөнхийдүү хэлбэртэй чулуу тархсан газар
158	B0722	Хотгор, хотос (khotgor, khotos). Газрын хэлбэр
159	B0723	Хошуу (khoshuu). Уулсаас салбарлан шувтрах нарийн хамар
160	B0724	Хөдөө (khöddö). Суурьшсан хот сууринаас хол нутаг, тариалангүй газар
161	B0725	Хөндий (khöndii). Хоёр хэсэг уул нуруу мэтийн хоорондуур үргэлжлэн алсалсан тэгш тавиу газар
162	B0726	Хөтөл (khötöl). Уул нуруудыг давахад тохиромжтой, ус хагалбарын хярын хотойсон онь газар.
163	B0727	Хургад (khurgad). Нар салхи зэрэг гадаад хүчний нөлөөгөөр хэсэгчлэлдэн бутарсан ихэнхдээ боржин чулуунаас тогтох суурь чулуу болон жижиг дов толгод бүхий газар.
164	B0728	Нүүр, хуруу, шанаа, дух, магнай, сээр, хажуу, сүвээ, хавирга, хөл, сүүл, гуя, тархи (nüür, khuruu, shanaa, dukh, magnai, seer, khajuu, süvee, khavirga, khöl, süül, guya, tarkhi). Уул, нурууны өвөр, хажуу болон уул, толгодоос салбарлан хэд хэдэн хэсэг сунаж тогтсон газар.
165	B0729	Хуудас (khuudas). Уул нуруудын хажуу дагуух дараалсан гүн жалгууд бүхий газар.
166	B0730	Хүрэм (khürem). Уулын орой, цээжин биеэр сул чулуу бүрхсэн газар, галт уулын дэлбэрэлтээс бүрэлдэж буй болсон хөнгөн чулуу
167	B0731	Хүрээ (khüree). Хагас дугуй хэлбэрээр тогтсон хад, элсэн хөвөө, ирмэг газар болон хүмүүс байрлаж оршин сууж байсан газар.
168	B0732	Цоорхой (tsoorkhoi). Ой, шугуйн чөлөө нь дэх өвслөг ургамал бүхий талбай
169	B0733	Эрэг, эргэцэг (ereg, eregtseg). Гол мөрөн, уул хадны хөвөөнд өнгийж тогтсон ирмэг
170	B0734	Ширдэг (shirdeg) өвс ургамалтай, зүлэгтэй дэвсгэр газар
171	B0735	Ихэр (ikher). Уул нуруудын болон талархаг нутагт орших хос уул, толгой буюу холбоо уул.
172	B0736	Түрүү (türüü). Газрын гадаргаас ундрэн гарах бүлэг булгууд бүхий газар.
173	B0737	Төхөм (tökhöm). Хөндийн уужим хонхор, хотгор, нугархаг газар
174	B0738	Хацар (khatsar). Ам хөндий дагуу байрлах хэсэгхэн эгц хажуу

MNS 6925-3 : 2021

175	B0739	Далан (dalan). Нуурын хаялгаар үүссэн болоод эртний мөстлийн адгийн дайр, мөн тусгай зориулалтаар байгуулсан байгууламжийн ул мөр.		
176	F0101	Туурь (tuuri). Хуучин хот балгасны үлдэгдэл бүхий газар.	Түүхэн, дурсгалт /historicalMonuments/	Хүний бүтээсэн /manMadeObject/
177	F0102	Хөшөө (khöshöö). Хад чулуун дээр ямар нэг зүйл тэмдэглэн үлдээж дурсгал болгон босгосон газар буюу байгалийн чулуун урлал.		
178	F0103	Балгас (balgas). Эртний хот болон эвдэрч сүйрсэн суурины үлдэгдэл бүхий газар.		
179	F0104	Хиргисүүр, хирвэс (khirgisüür, khirves). Эрт дээр цагт үхэгсдийн хүүрийг оршуулсан булш, тахилгын байгууламж.		
180	F0105	Цайз, хэрэм (tsaiz, kherem). Хэрмээр хүрээлэн хороолж бэхэлсэн багахан хот		
181	F0106	Булш (bulsh). Эрт эдүгээгийн хүний хүүр, оршуулга бүхий газар.		
182	F0201	Бууц (buuts). Нутаглаж, буудаллаж байсан, малын хашаа хороо байсан ором үлдэцтэй газар.		
183	F0203	Өвөлжөө (övöljöö). Өвлийн улиралд малаа байрлуулахаар барьсан хашаа саравчтай газар.	Барилга, байгууламж /buildings/	
184	F0204	Шуудуу (shuuduu). Ус урсах хиймэл буюу ерийн тогтсон нарийвтар суваг		
185	F0205	Зам (zam). Машин, тэрэг, чаргаар зорчих хос мөр, газрын хуучин сорив, засмал байгууламж.		
186	F0206	Өтөг (ötög). Малын бууц бүхий буюу баавгай ичдэг болон зэрлэг гахай тогтмол байрлан өвөлждөг газар.		
187	F0207	Байшин (baishin). Хүн суух, юм агуулах, мод, туйпуу, тоосго, шавар, чулуу зэргээр барьсан барилга		
188	F0208	Гүүр (güür). Гол мөрөн, гуу жалга, төмөр зам зэргийг саад бартаагүй нэвтрэн гарахад зориулан барьсан байгууламж		
189	F0209	Уурхай (uurkhai). Ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон ашиглаж буй газар.		
190	F0210	Суурь (suuri). Хамтран мал аж ахуй эрхлэх нэгж, нэгэн үед юм байсан ор,буурь.		
191	F0211	Хашаа (khashaa). Мал, эд зүйлийг хамгаалах зорилгоор тойруулж барьсан зүйл		
192	F0212	Хороо (khoroo). Хүйтний улиралд мал хашихад зориулсан чулуу, мод зэргээр хийсэн хашаа		
193	F0213	Шан (shan). Тариалангийн хоёр далангийн хоорондох газар		

194	F0214	Геологи (geologi). Геологийн эрдэс чулуулагтай холбоотой дэвсгэр нэр		
195	F0215	Үйлдвэр (üildver). Түүхий эдийг боловсруулах газар		
196	F0216	Усалгааны систем (usalgaanySistyem). Усалгааны системийн дэвсгэр нэр		
197	F0217	Зуслан (zuslan). Хүмүүсийн зуны цагт буудаллан, намар хүртэл нутаглах газрыг нэрлэсэн дэвсгэр нэр		
198	F0301	Суварга (suvarga). Бурхны шашны дурсгалын хөшөө, үнэт зүйл агуулах уран барилгын нэг төрлийг нэрлэсэн дэвсгэр нэр	Шашин /religion/	
199	F0302	Сүм, дуган, хийд (süm, dugan, khiid). Бурхан тахих, ном сургаал айлдах, хурал хурах зэрэг шашны ёсны зан үйл үйлдэх орон байр		
200	F0303	Жас (jas). Сүм, дуган, хурал номын сан хөмрөг, мал хөрөнгө эрхлэх газар, хийдийн аж ахуйн дэвсгэр нэр		

В.1.6 Газар зүйн нэрийн объектын ангилал – Named place type value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Хил зааг (boundary)	Төр засаг, захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагаа явуулах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын тогтолцоогоор тодорхойлогдсон нэгжийн нэр. Манай улс нь улс, аймаг, сум, тосгон, багаас, нийслэл нь, дүүрэг, хорооноос бүрдэнэ.
2	Барилга (building)	Орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг хүний гараар бүтээгдсэн бүх барилга байгууламжийн нэр орно
3	Ус зүй (hydrography)	Ус зүйн элементүүд. Үүнд далай тэнгис, гол мөрөн нуур, худаг булаг болон голын ай сав, дэд сав газрын нэр хамрагдана.
4	Тээврийн сүлжээ (transportNetwork)	Зам, төмөр зам, агаар, усан замын тээврийн сүлжээ болон холбогдох дэд бүтэц. Өөр өөр сүлжээнүүдийн холбоосыг агуулдаг.
5	Түүхэн дурсгалт газар (historicalMonuments)	Байгалийн хүний гараар бүтээгдэн бий болсон эртний булш, бунхан, хиргисүүр, хөшөө чулуу, хадны сүг зураг, сүм хийдийн туурь зэргийн нэр хамрагдана.
6	Өндөр (elevation)	Газрын гадаргаас босоо чиглэлд тооцсон абсолют хэмжигдэхүүний утга. Газрын гадаргын харьцангуй өндрөөр тодорхойлогдох орон зайн объект.
7	Хаяг (address)	Хаягжуулсан газрын нэр.
8	Геологи (geology)	Газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг хайх, судлах (Жишээлбэл: алт, зэс гэх мэт).

9	Бусад (other)	Дээрх ангилалд хамаарагдаагүй орон зайн объект.
---	---------------	---


В.1.7 Газар зүйн нэрийн төлөв – Name status value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	Батлагдсан (official)	Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан ёсоор батлагдсан.
2	Батлагдаагүй (unofficial)	Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан ёсоор батлагдаагүй.


С хавсралт (норматив)

UML (нэгдсэн загварчлалын хэл)-ийн диаграмм


Орон зайн объектын төрлүүд тэдгээрийн шинж хэлбэрүүд болон холбогдсон төрлүүд нь UML-ийн ангиллын диаграммд үзүүлсэн байна.




С.1-р зураг - UML диаграмм: Газар зүйн нэрийн биет болон өгөгдөл төрөл




C.2-р зураг - UML диаграмм: Газар зүйн нэрийн биет төрөл



С.3-р зураг - UML диаграмм: Биетийн төрлийн диаграмм



С.4-р зураг - UML диаграмм: Газар зүйн нэрийн ерөнхий диаграмм



С.5-р зураг - UML диаграмм: Газар зүйн нэрийн кодын жагсаалт

D хавсралт
(норматив)

Өгөгдлийн чанар

D.1 – p хүснэгт – Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийг үнэлэх чанарын шалгуур үзүүлэлтүүд

Хэсэг	Өгөгдлийн чанарын элемент	Өгөгдлийн чанарын дэд элемент	Тодорхойлолт	Үнэлгээний хамрах хүрээ
1	Бүрэн бүтэн байдал	Орхигдол	Хамрах хүрээгээр тодорхойлсон өгөгдлийн сангаас орхигдсон өгөгдөл	Орон зайн объектын төрөл
2	Утга агуулгын нийцтэй байдал	Ерөнхий нийцтэй байдал	Концепц схемийн дүрмийг дагаж мөрдөх	орон зайн объектын төрөл; орон зайн объект
3	Утга агуулгын нийцтэй байдал	Домэйний нийцтэй байдал	Домэйн утгыг дагаж мөрдөх	орон зайн объектын төрөл; орон зайн объект
4	Байрлалын нарийвчлал	Үнэмлэхүй буюу гадаад нарийвчлал	Солбицлын утгууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл хамгийн бага алдааны нарийвчлалыг хангах	

D.1.1 Бүрэн бүтэн байдал – Орхигдол

Бүрэлдэхүүн хэсэг	Тайлбар
Нэр	орхигдол
Хураангуй нэр	-
Элементийн нэр	бүрэн бүтэн байдал
Дэд элементийн нэр	орхигдол
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	алдаа заагч
Тодорхойлолт	өгөгдөлд гээгдсэн зүйлийг заагч
Үнэлгээний цар хүрээ	орон зайн объектын төрөл: бүх орон зайн объектын төрлүүд, өгөгдлийн багц, өгөгдлийн багцын цуврал
Хамрах хүрээ	орон зайн объектын төрөл: бүх орон зайн объектын төрлүүд, өгөгдлийн багц, өгөгдлийн багцын цуврал
Үзүүлэлт	-
Утгын төрөл	бодит тоо, хувь, харьцаа
Утгын бүтэц	дан утга, багц, дараалал, хүснэгт, матриц эсвэл бүрхэц
Эх сурвалж	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	-
Тодорхойлогч хэмжүүр	7

D.1.2 Утга агуулгын нийцтэй байдал – Ерөнхий нийцтэй байдал

Бүрэлдэхүүн хэсэг	Тайлбар
Нэр	концепц схемд нийцэхгүй байх

MNS 6925-3 : 2021

Хураангуй нэр	-
Элементийн нэр	утга агуулгын нийцтэй байдал
Дэд элементийн нэр	ерөнхий нийцтэй байдал
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	алдаа заагч
Тодорхойлолт	зүйл нь холбогдох ерөнхий схемийн дүрмүүдтэй нийцэхгүй байгааг зааж
Тайлбар	хэрэв концепц схемийн ил ба далд хэлбэрээр тодорхойлсон бол эдгээр дүрмийг дагаж мөрдөнө. эдгээр дүрмийн зөрчил нь тодорхой тодорхойлогдсон хүлцэл дотор биетийг буруу байрлуулах, биетийн давхардал болон хүчингүй давхцал зэрэг болно.
Үнэлгээний цар хүрээ	орон зайн объект / орон зайн объектын төрөл
Хамрах хүрээ	өгөгдлийн багц
Үзүүлэлт	-
Утгын төрөл	бүхэл тоо
Утгын бүтэц	-
Эх сурвалж	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	
Тодорхойлогч хэмжүүр	10

D.1.3 Утга агуулгын нийцтэй байдал – Домэйний нийцтэй байдал

Бүрэлдэхүүн хэсэг	Тайлбар
Нэр	домэйн утгын үл нийцэл
Хураангуй нэр	-
Элементийн нэр	утга агуулгын нийцтэй байдал
Дэд элементийн нэр	домэйний нийцтэй байдал
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	алдаа заагч
Тодорхойлолт	зүйл нь домэйн утгатай нийцэхгүй байгааг заах
Тайлбар	-
Үнэлгээний цар хүрээ	орон зайн объект / орон зайн объектын төрөл
Хамрах хүрээ	өгөгдлийн багц
Үзүүлэлт	-
Утгын төрөл	бүлийн хувьсагч (true утга нь ерөнхий схемийн дүрмүүдтэй нийцэхгүй байгааг заана)
Утгын бүтэц	-
Эх сурвалж	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	-
Тодорхойлогч хэмжүүр	14

D.1.4 Байрлалын нарийвчлал – Үнэмлэхүй буюу гадаад нарийвчлал

Бүрэлдэхүүн хэсэг	Тайлбар
Нэр	байрлалын тодорхой бус байдлын дундаж утга (1D, 2D ба 3D)
Хураангуй нэр	-
Элементийн нэр	байрлалын нарийвчлал

Дэд элементийн нэр	үнэмлэхгүй гадаад нарийвчлал
Өгөгдлийн чанарын үндсэн хэмжүүр	хэрэглэхгүй
Тодорхойлолт	байрлалын тодорхойгүй байдлыг тогтооход зориулсан тодорхойгүй байрлалын дундаж утга нь хэмжсэн байрлал ба байвал зохих бодит байрлал хоорондын зайгаар тодорхойлогдоно.
Тайлбар	хэмжсэн байрлал ба тохирох үнэн зөв байрлал хоёрын хоорондын зайг тодорхойлсон байрлалын тохиромжгүй байдал бүхий газарт байгаа байрлалын тодорхойгүй байдлын дундаж утга 1 хэмжээст $e_i = x_{mi} - x_{ti}$ 2 хэмжээст $e_i = \sqrt{(x_{mi} - x_{ti})^2 + (y_{mi} - y_{ti})^2}$ 3 хэмжээст $e_i = \sqrt{(x_{mi} - x_{ti})^2 + (y_{mi} - y_{ti})^2 + (z_{mi} - z_{ti})^2}$ хөндлөн үнэмлэхүй буюу гадаад байрлалуудын дундаж байрлалын тохиромжтой бус байдлыг дараах томъёогоор тооцоолно. $e = \frac{1}{N} \sum_{i=1}^n e_i$ харилцан зохицлыг тогтооход зориулагдсан шалгуур үзүүлэлтийг тодорхойлно (тухайлбал хамгийн ойрын байрлал ба орой хэсэгт зохицох эсвэл шугам дагасан байхаар). харилцан зохицох цэгүүдийг олох шалгуурууд нь тухайн өгөгдлийн чанарын үнэлгээний үр дүнгийн хамт байвал зохино. энэхүү өгөгдлийн чанарын хэмжүүр нь стандарт хазайлтаас ялгаатай.
Үнэлгээний цар хүрээ	өгөгдлийн багц
Хамрах хүрээ	өгөгдлийн багц
Үзүүлэлт	-
Утгын төрөл	хэмжүүр
Утгын бүтэц	дан утга, багц, дараалал, хүснэгт, матриц эсвэл бүрхэц
Эх сурвалж	ISO/DIS 19157 Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар
Жишээ	-
Тодорхойлогч хэмжүүр	28 (ISO 19157)

Ном зүй

- [1] INSPIRE D2.8.I.3, 2014, Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт-Техникийн шаардлага
- [2] 2007/2/EC Европын Холбооны Орон зайн мэдээллийн өгөгдөл-Стандарт;
- [3] ISO 15924:2004, Газар зүйн нэршлийн үсгийн хэлбэрийг кодоор төлөөлж илэрхийлэх
- [4] ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;
- [5] ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;
- [6] ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем,
- [7] Техникийн засвар 1;
- [8] ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн тулгуур солбицол;
- [9] ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;
- [10] ISO 19118: 2006, Газар зүйн мэдээлэл – Кодлолт;
- [11] ISO 19135: 2007, Газар зүйн мэдээлэл – Бүртгэлийн процедур;
- [12] ISO 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;
- [13] ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;
- [14] MNS 1-1:2006, Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт
- [15] MNS 1-2:2006, Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт
- [16] MNS ****:2019, Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн стандарт /төсөл/
- [17] MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо
- [18] MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл
- [19] Геодези, зураг зүйн тухай хууль
- [20] Э.Равдан. “Газар зүйн дэвсгэр нэрийн зурагт тайлбар толь”, УБ. 2019
- [21] Д.Энхбаяр, Б.Авирмэд, Д.Даш, Б.Сайнбуян. “Монгол орны газар зүйн дэвсгэр нэрийн тайлбар толь”, УБ.2020